

1**ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ БА ЗАСАГЛАЛЫН ЧАНАР****Б.Баярадаваа**

Эдийн засгийн өсөлтийн салбарт 1980-аад он хүртэл хийгдэж байсан гадаад өсөлтийн онолын судалгаа нь улс орнуудын дотоод бүтэц рүү хандсан судалгаанд чиглэгдэж байна. Өөрөөр хэлбэл дэлхийн улс орнуудын орлого, түүний ялгаатй байдал нь тэдгээр улсуудын дотоод бүтцээс нь ихээхэн хамааралтай гэж үзэх болсон. Улс орнуудын бүтцийн ялгаатай байдлыг илэрхийлэх нэг үзүүлэлт нь тэдний төрийн үйл ажиллагаа, засаглалын чанар юм. Тодруулбал улс орон бүр төртэй боловч түүний үйл ажиллагаа, чанар нь харилцан адилгүй ялгаатай байх нь тэдний орлогын болон эдийн засгийн өсөлтийн ялгаатай байдлын нэг шалтгаан байж болох юм гэсэн үзэл, санаа нэлээд өргөн хүрээтэй гарч ирсэн байна.

Өнөөдөр Монгол улсын өмнө тулгарч, субъект бүрийн анхаарлыг татаж буй асуудал бол хөгжлийн гарцыг олох юм. Энэ үүднээс миний бие манай улсын хөгжлийн хурдыг сааруулж буй хүчин зүйлүүдийн нэг нь засаглалын чанар байж магадгүй гэсэн таамаглалд үндэслэн дэлхий улс орнуудын хувьд засаглалын чанар ба орлого, орлогын өсөлтийн хамаарлыг судлах зорилго тавьж энэхүү эмпирик судалгааг хийсэн болно.

Энэ судалгаандаа 147 улс орныг түүвэрлэн авч, РРР-ийн зэрэгцүүлэлтийн аргаар дэлхийн банкнаас тооцож, ам.доллараар илэрхийлсэн нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн, түүний өсөлтийн хувь, дэлхийн банкнаас тооцож гаргасан засаглалын чанарын индекс зэрэг үзүүлэлтүүдийг ашигласан.

I

Дэлхийн улс орнуудын хөгжлийн түвшин, хүн амын дундаж орлогын түвшин түүний өсөлтийн хувь зэрэг нь харилцан адилгүй эрс тэс

ялгаатай байна. Энэ нь тэдгээр улс орнуудын бүтцийн шинж чанартай холбоотой гадаад болон дотоод маш олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа нь ойлгомжтой юм. Тэдгээр нөлөөлөгч хүчин зүйлүүдийн нэг нь улс орон бүрийн засаглалын буюу төрийн үйл ажиллагааны чанарын асуудал юм. Өөрөөр хэлбэл улс орон бүрийн хувьд төрийн нийгэм, эдийн засгийн харилцаанд гүйцэтгэх үүрэг, оролцох оролцоо, чанарын харилцан адилгүй ялгаатай байдал нь тэдгээр улсуудын хөгжлийн түвшин, хүн амын орлогын түвшин, эдийн засгийн өсөлтийн ялгаатай байдлын нэг хариулт байж болох юм. Ийм учраас энэхүү засаглалын оролцоо ба чанарын асуудал нь дэлхий нийтийн эрдэмтэн судлаачдын анхаарлыг маш ихээр татаж эхлээд байна. Үүнтэй уялдуулан Дэлхийн банкнаас улс орнуудын төрийн үйл ажиллагааны чанарыг хэмжих зорилгоор засаглалын чанарын индекс гэсэн үзүүлэлтийг тооцож эхэлсэн. Засаглалын чанарын индекс нь дараах 6 индексээс бүрддэг байна. Үүнд:

Засаглалын чанарын индекс нь 3 бүлэгт харъяалагдах 6 индексээс бүрдэнэ. Үүнд:

1. Дараах хоёр индексээр засгийн газрын хэрхэн сонгогдож, яаж ажиллаж, ямар байдлаар солигдож байна вэ? гэдгийг харуулна. Үүнд:

- Сонголт ба Хариуцлагатай байдлын индекс. Энэ индекс нь төрийн байгууллагын сонгуульд нийт сонгогчид болон бусад байгууллагууд ямар байдлаар, яаж оролдог, засаглал дахь сонгогчдын төлөөллийн бүтэц, хариуцлага тооцох механизм, хэвлэлийн эрх чөлөө ямар түвшинд байна вэ? гэдгийг харуулдаг.
- Улс төрийн тогтвортой байдлын индекс. Энэ индексээр засгийн газар нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хууль зөрчсөн болон хүчирхийллийн шинжтэй үйлдэл, үйл ажиллагаануудыг хэрхэн зохицуулж, арилгаж чадаж байна вэ? гэдгийг хэмжинэ.

2. Харин засгийн газрын сайн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чадварыг дараах хоёр индексээр илэрхийлдэг.

- Засгийн газрын үр ашигт байдлын индекс. Энэ индекс нь нийгмийн үйлчилгээний хангамжийн чанар, төрийн албан хаагчдын чадвар, нийгмийн үйлчилгээний улс төрийн дарамтаас хамаарах хамаарал зэргийг илэрхийлнэ.

- Зохицуулалтын чанарын индекс. Энэ индекс нь зохицуулалт хийж буй хүч, засаглалын хүнд суртал буюу шат дамжлагын үр ашиг ба чанарыг хэмжинэ.

3. Дараах хоёр индексээр иргэд болон тэдний хоорондох харилцааг зохицуулж байдаг төрийн байгууллагуудын хоорондын харилцан бие биенээ хүндлэх асуудлыг илэрхийлнэ.

- Хууль дээдлэлтийн индекс. Энэ индекс нь шүүхийн бүтэц, хуулийг мөрдүүлэх нөөц, бололцоо, өмчийн эрхийн хамгаалалт зэрэг шалгууруудаар эрх зүйн систем болон түүний хэрэгжилтийг хэмждэг.
- Авилгалын хяналтын индекс. Энэ индексээр хувийн эрх ашгийн үүднээс эрх мэдлийг ашиглах явдлыг, авилгал, хээл хахуулийг арилгах ямар нөөц боломж, чадавхи байгааг хэмжинэ.

Дээрх засаглалын чанарыг илэрхийлж буй индекс нь -2.5-аас +2.5-ийн хооронд утга авах бөгөөд +2.5 руу ойртох нь тухайн үзүүлэлт сайжирч буйг илэрхийлэх болно. Дэлхийн улс орнуудын хүн амын орлогын түвшин болон эдийн засгийн өсөлтийн түвшний ялгаатай байдалд засаглалын чанар ямар нэгэн байдлаар нөлөөтэй эсэхийг тодорхойлохын тулд дараах таамаглалыг тавьж байна. Үүнд:

- Тухайн улсын хүн амын орлогын түвшинг тухайн улсын нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн /цаашид ДНБ гэх/ -ээр илэрхийлнэ.
- Тухайн орны эдийн засгийн өсөлтийг тухайн улсын нэг хүнд ноогдох ДНБ-ий өсөлтийн хувиар хэмжинэ.
- Дэлхийн банкнаас тооцож гаргасан засаглалын индекс нь засаглалын чанарыг илэрхийлж, хэмжиж чадна.
- Нэг хүнд ноогдох ДНБ-ий өсөлт болон засаглалын индексийн хооронд, мөн нэг хүнд ноогдох ДНБ болон засаглалын индексийн хооронд шугаман хамаарал оршино.

$$y_i = \beta_0 + \beta_1 * ind_i$$

(1)

Энд: y_i - $i - p$ улсын нэг хүний жилийн дундаж орлого буюу нэг хүнд ноогдох ДНБ

ind_i - $i - p$ улсын засаглалын чанарыг илэрхийлсэн тухайн индексийн утга

β_1 - засаглалын тухайн индексийн 1 функтын ялгаатай байдал нь y хувьсагчийн буюу нэг хүнд ноогдох эдийн засгийн өсөлтийн түвшин болон ДНБ-ий β_1 нэгжийн ялгааг үүсгэнэ гэдгийг илэрхийлнэ.



II

Улс орнуудын бүтцийн ялгаатай байдалтай холбоотойгоор засаглалын чанарын үзүүлэх нөлөө харилцан адилгүй ялгаатай байж болох тул судалгааг хийхдээ судалгаанд хамрагдсан улс орнууд буюу түүврээ дараах 5 дэд түүвэрт, 5 хэсэгт ангилж судалсан болно. Үүнд:

- Буурай хөгжилтэй улс орнууд /735 ам.дол ба түүнээс бага орлоготой/
- Хөгжиж буй улс орнууд /735 - 9075 ам.долларын орлоготой/
- Өндөр орлоготой улс орнууд /9076 ам.дол ба түүнээс их орлоготой/
- OECD-ийн гишүүн улс орнууд
- Нийт түүвэр буюу судалгаанд хамрагдсан нийт улс орнууд

Дээрх (1) загвараар түүвэр тус бүрийн хувьд улс орнуудын нэг хүнд ноогдох ДНБ болон нэг хүнд ноогдох ДНБ-ий өсөлтийг засаглалын 6 индекс тус бүрээс хамааруулан хамгийн бага квадратын аргад тулгуурлан cross sectional үнэлгээ хийхэд дараах үр дүн гарч байна.

Дээрх таван дэд түүвэр тус бүрийн хувьд засаглалын чанар улс орнуудын хүн амын дундаж орлогын түвшний ялгаатай байдлын шалтгаан болж байгаа эсэхийг судалж үзэхэд дараах үр гарч байна.



Буурай хөгжилтэй улс орнуудын хувьд засаглалын чанар нь хүн амын дундаж орлогын ялгаатай байдлын шалтгаан болж байна уу? гэдгийг засаглалын 6 индекс тус бүрийн хувьд судалж үзэхэд Авилгалын хяналтын индексээс бусад индексүүд нь статистикийн хувьд ач холбогдолгүй гарсан. Энэ нь Авилгалын хяналтын индексээс бусад индексүүд нь буурай хөгжилтэй улс орнуудын хувьд дундаж орлого буюу нэг хүнд ноогдох ДНБ-ий ялгаатай байдлыг шалтгаан болохгүй, харин Авилгалын хяналтын индекс нь дээрхийн ялгаатай байдлын шалтгаан болно гэдгийг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл буурай хөгжилтэй улс орнууд хувьд авилгалын хяналтыг сайжруулж чадвал хүн амын дундаж орлогоо нэмэгдүүлэх боломжтой гэдгийг илэрхийлж байна.

Авилгалын хяналтын индекс:

$$y_i = 2103.36 + 970.05 * ind_i + 6027.04 * DUM_i + e_i$$

<i>t</i> - stat	(5.24)	(1.791)	(8.772)
<i>st.e</i>	(401.69)	(541.57)	(687.06)
Adj $R^2 = 0.68$,	F - stat = 41.72		

DUM_i – улс орнуудын бүтцийн ялгааг арилгах чанарын хувьсагч. Дээрх үнэлгээнээс тухайн буурай хөгжилтэй улсын авилгалын хянах боломж, чадвар 0.1 функтээр өсөхөд нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ ойролцоогоор 97 ам.\$-оор өснө гэсэн дүгнэлтийг хийж байна.

Хөгжиж буй улс орнуудын хувьд засаглалын чанар нь хүн амын дундаж орлогын ялгаатай байдлын шалтгаан болж байна уу? гэдгийг засаглалын 6 индекс тус бүрийн хувьд судалж үзэхэд бүх индексүүд

бүгд статистикийн хувьд ач холбогдолтой гарсан. Энэ нь засаглалын чанарыг илэрхийлсэн дээрх 6 үзүүлэлтээр илэрхийлэгдсэн засаглалын чанарын асуудлын ялгаатай байдал хөгжиж буй улс орнуудын хувьд дундаж орлого буюу нэг хүнд ноогдох ДНБ-ий ялгаатай байдлын шалтгаан болж байна гэдгийг харуулж байна.

Сонголт ба Хариуцлагатай байдлын индекс:

$$y_i = 1705.435 + 626.13 * ind_i + 6646.61 * DUM_i + e_i$$

<i>t</i> - stat	(9.08)	(2.84)	(12.19)
<i>st.e</i>	(187.89)	(220.51)	(545.27)
<i>Adj R</i> ² = 0.63,	<i>F</i> - stat = 90.01		

Авилгалын хяналтын индекс:

$$y_i = 2168.06 + 1720.43 * ind_i + 5631.13 * DUM_i + e_i$$

<i>t</i> - stat	(11.55)	(6.18)	(10.84)
<i>st.e</i>	(187.77)	(278.55)	(519.55)
<i>Adj R</i> ² = 0.71,	<i>F</i> - stat = 128.78		

Засгийн газрын үр ашигтай байдлын индекс:

$$y_i = 2028.31 + 1465.09 * ind_i + 5921.14 * DUM_i + e_i$$

<i>t</i> - stat	(10.89)	(5.41)	(11.28)
<i>st.e</i>	(186.25)	(270.73)	(525.01)
<i>Adj R</i> ² = 0.69,	<i>F</i> - stat = 117.36		

Хууль дээдлэлтийн индекс:

$$y_i = 2125.9 + 1644.395 * ind_i + 5580.78 * DUM_i + e_i$$

<i>t</i> - stat	(11.87)	(6.51)	(10.91)
<i>st.e</i>	(179.13)	(252.51)	(511.66)
<i>Adj R</i> ² = 0.72,	<i>F</i> - stat = 134.27		

Зохицуулалтын чанарын индекс:

$$y_i = 1786.06 + 1448.61 * ind_i + 6223.35 * DUM_i + e_i$$

<i>t</i> - stat	(10.96)	(5.86)	(12.57)
<i>st.e</i>	(163.03)	(247.31)	(495.17)
<i>Adj R</i> ² = 0.70,	<i>F</i> - stat = 123.83		

Улс төрийн тогтвортой байдлын индекс:

$$y_i = 1684.86 + 628.94 * ind_i + 6549.97 * DUM_i + e_i$$

<i>t</i> - stat	(9.22)	(3.04)	(11.95)
<i>st.e</i>	(182.79)	(206.65)	(548.11)
<i>Adj R</i> ² = 0.64,	<i>F</i> - stat = 91.56		

Дээрх индекс тус бүрийн хувьд хийсэн үнэлгээний үр дүнд үндэслэн индексүүд 0.1 функтээр өсөхөд нэг хүнд ноогдох ДНБ ямар хэмжээгээр нэмэгдэхийг сонирхвол: Сонголт ба Хариуцлагатай байдлын индекс 0.1 функтээр өсөхөд 62.6 ам.\$-оор, Авилгалын хяналтын индекс 0.1 функтээр өсөхөд 172 ам.\$-оор, Засгийн газрын үр ашигтай байдлын индекс 0.1 функтээр өсөхөд 146.5 ам.\$-оор, Хууль дээдлэлтийн индекс 0.1 функтээр өсөхөд 164.4 ам.\$-оор, Зохицуулалтын чанарын индекс 0.1 функтээр өсөхөд 144.9 ам.\$-оор, Улс төрийн тогтвортой байдлын индекс 0.1 функтээр өсөхөд 62.9 ам.\$-оор тус тус өсөх үр дүн харагдаж байна. Эндээс хөгжиж буй орны хувьд авилгалын хяналтыг сайжруулж чадвал хамгийн ихээр нэг хүнд ноогдох ДНБ-ээ өсгөх боломжтой гэсэн дүгнэлт гарч байна.

Өндөр орлоготой улс орнуудын хувьд засаглалын чанар нь хүн амын дундаж орлогын ялгаатай байдлын шалтгаан болж байна уу? гэдгийг засаглалын 6 индекс тус бүрийн хувьд судалж үзэхэд Засгийн газрын үр ашигтай байдлын индекс, Хууль дээдлэх индекс, Улс төрийн тогтвортой байдлын индексүүд статистикийн хувьд ач холбогдолтой гарсан. Энэ нь Засгийн газрын үр ашигтай байдлын индекс, Хууль дээдлэх индекс, Улс төрийн тогтвортой байдлын индексүүд өндөр орлоготой улс орнуудын хувьд дундаж орлого буюу нэг хүнд ноогдох ДНБ-ий ялгаатай байдлын шалтгаан болж байхад, Зохицуулалтын чанарын индекс, Авилгалын хяналтын индекс, Сонголт ба Хариуцлагатай байдлын индекс нь нэг хүнд ноогдох ДНБ-ий ялгаатай байдлыг тайлбарлахад чухал нөлөөтэй биш гэдгийг харуулж байна.

Засгийн газрын үр ашигтай байдлын индекс:

$$y_i = 14414.35 + 6927.9 * ind_i + 8580.895 * DUM_i + e_i$$

<i>t</i> - stat	(2.4)	(1.96)	(1.8)
<i>st.e</i>	(5998.48)	(3535.17)	(4762.57)
<i>Adj R</i> ² = 0.24,	<i>F</i> - stat = 4.53		

Хууль дээдлэх индекс:

$$y_i = 15104.06 + 6308.51 * ind_i + 8938.17 * DUM_i + e_i$$

<i>t</i> - stat	(2.31)	(1.68)	(1.84)
<i>st.e</i>	(6538.95)	(3746.67)	(4852.57)
<i>Adj R</i> ² = 0.21,	<i>F</i> - stat = 3.91		

Улс төрийн тогтвортой байдлын индекс:

$$y_i = 15608.84 + 8193.415 * ind_i + 9511.44 * DUM_i + e_i$$

<i>t</i> - stat	(2.6)	(1.69)	(2.46)
<i>st.e</i>	(6002.19)	(4842.78)	(3868.91)
<i>Adj R</i> ² = 0.25,	<i>F</i> - stat = 4.74		

Дээрх индекс тус бүрийн хувьд хийсэн үнэлгээний үр дүнд үндэслэн дээрх индексүүд 0.1 функтээр өсөхөд нэг хүнд ноогдох ДНБ ямар хэмжээгээр нэмэгдэхийг сонирхвол: Засгийн газрын үр ашигтай байдлын индекс 0.1 функтээр өсөхөд 692.8 ам.\$-оор, Хууль дээдлэлтийн индекс 0.1 функтээр өсөхөд 630.9 ам.\$-оор, Улс төрийн тогтвортой байдлын индекс 0.1 функтээр өсөхөд **819.3** ам.\$-оор тус тус өсөх үр дүн харагдаж байна. Эндээс өндөр орлоготой орны хувьд улс төрийн тогтвортой байдлыг хангаж чадвал хамгийн ихээр нэг хүнд ноогдох ДНБ-ээ өсгөх боломжтой гэсэн дүгнэлт гарч байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын/OECD/ гишүүн улс орнуудын хувьд засаглалын чанар нь хүн амын дундаж орлогын ялгаатай байдлын шалтгаан болж байна уу? гэдгийг засаглалын 6 индекс тус бүрийн хувьд судалж үзэхэд бүх индексүүд бүгд статистикийн хувьд ач холбогдолтой гарсан. Энэ нь засаглалын чанарыг илэрхийлсэн дээрх 6 үзүүлэлтээр илэрхийлэгдсэн засаглалын чанарын асуудлын ялгаатай байдал нь OECD-ийн гишүүн

улс орнуудын хувьд дундаж орлого буюу нэг хүнд ноогдох ДНБ-ий ялгаатай байдлын шалтгаан болж байна гэдгийг харуулж байгаа юм.

Сонголт ба Хариуцлагатай байдлын индекс:

$$y_i = 7987.24 + 12243.56 * ind_i + 8690.62 * DUM_i + e_i$$

<i>t</i> - stat	(2.2)	(4.41)	(1.66)
<i>st.e</i>	(3630.81)	(2778.06)	(5235.51)
<i>Adj R</i> ² = 0.42,	<i>F</i> - stat = 11.13		

Авилгалын хяналтын индекс:

$$y_i = 11580.55 + 7582.65 * ind_i + 8624.67 * DUM_i + e_i$$

<i>t</i> - stat	(4.56)	(4.91)	(1.77)
<i>st.e</i>	(2537.24)	(1544.1)	(4866.09)
<i>Adj R</i> ² = 0.52,	<i>F</i> - stat = 16.44		

Засгийн газрын үр ашигтай байдлын индекс:

$$y_i = 7895.8 + 11034.89 * ind_i + e_i$$

<i>t</i> - stat	(2.95)	(6.37)
<i>st.e</i>	(2680.45)	(1732.28)
<i>Adj R</i> ² = 0.59,	<i>F</i> - stat = 40.58	

Хууль дээдлэлтийн индекс:

$$y_i = 8811.03 + 9720.53 * ind_i + 8509.52 * DUM_i + e_i$$

<i>t</i> - stat	(3.34)	(5.74)	(1.9)
<i>st.e</i>	(2634.85)	(1692.06)	(4472.84)
<i>Adj R</i> ² = 0.60,	<i>F</i> - stat = 21.66		

Зохицуулалтын чанарын индекс:

$$y_i = 19689.09 * ind_i + e_i$$

$$t - stat \quad (18.72)$$

$$st.e \quad (1051.465)$$

$$Adj R^2 = 0.45$$

Улс төрийн тогтвортой байдлын индекс:

$$y_i = 10406.3 + 11484.14 * ind_i + 10166.85 * DUM_i + e_i$$

$$t - stat \quad (3.73) \quad (4.84) \quad (2.51)$$

$$st.e \quad (2793.2) \quad (2374.04) \quad (4055.55)$$

$$Adj R^2 = 0.50, \quad F - stat = 14.84$$

Дээрх индекс тус бүрийн хувьд хийсэн үнэлгээний үр дүнд үндэслэн дээрх индексүүд 0.1 функтээр өсөхөд нэг хүнд ноогдох ДНБ ямар хэмжээгээр нэмэгдэхийг сонирхвол: Сонголт ба Хариуцлагатай байдлын индекс 0.1 функтээр өсөхөд 1224.4 ам.\$-оор, Авилгалын хяналтын индекс 0.1 функтээр өсөхөд 758.3 ам.\$-оор, Засгийн газрын үр ашигтай байдлын индекс 0.1 функтээр өсөхөд 1103.5 ам.\$-оор, Хууль дээдлэлтийн индекс 0.1 функтээр өсөхөд 972 ам.\$-оор, Зохицуулалтын чанарын индекс 0.1 функтээр өсөхөд **1969** ам.\$-оор, Улс төрийн тогтвортой байдлын индекс 0.1 функтээр өсөхөд 1148.4 ам.\$-оор тус тус өсөх үр дүн харагдаж байна. Эндээс хөгжиж буй орны хувьд зохицуулалтын чанарыг сайжруулж чадвал хамгийн ихээр нэг хүнд ноогдох ДНБ-ээ өсгөх боломжтой гэсэн дүгнэлт гарч байна.

Түүвэрт багтсан нийт улс орнуудын хувьд засаглалын чанар нь хүн амын дундаж орлогын ялгаатай байдлын шалтгаан болж байна уу? гэдгийг засаглалын 6 индекс тус бүрийн хувьд судалж үзэхэд Зохицуулалтын чанарын индексээс бусад индексүүд нь статистикийн хувьд ач холбогдолтой гарсан. Энэ нь Зохицуулалтын чанарын индексээс бусад индексүүдээр илэрхийлэгдэх засаглалын чанарын асуудлуудын ялгаатай байдал нь улс орнуудын хувьд дундаж орлого буюу нэг хүнд ноогдох ДНБ-ий ялгаатай байдлыг шалтгаан болдог гэдгийг харуулж байна.

Сонголт ба Хариуцлагатай байдлын индекс:

$$\log(y_i) = 8.49 + 0.83 * ind_i + e_i$$

$$t - stat \quad (124.47) \quad (10.94)$$

$$st.e \quad (0.068) \quad (0.076)$$

$$Adj R^2 = 0.45, \quad F - stat = 119.73$$

Авилгалын хяналтын индекс:

$$y_i = 8181.89 + 8507.22 * ind_i + e_i$$

$$t - stat \quad (22.06) \quad (22.39)$$

$$st.e \quad (370.82) \quad (379.98)$$

$$Adj R^2 = 0.77, \quad F - stat = 501.26$$

Засгийн газрын үр ашигтай байдлын индекс:

$$y_i = 8110.28 + 8785.06 * ind_i + e_i$$

$$t - stat \quad (20.57) \quad (20.7)$$

$$st.e \quad (394.23) \quad (424.46)$$

$$Adj R^2 = 0.75, \quad F - stat = 428.36$$

Хууль дээдлэлтийн индекс:

$$y_i = 8038.92 + 8586.45 * ind_i + e_i$$

$$t - stat \quad (20.75) \quad (21.22)$$

$$st.e \quad (387.34) \quad (404.69)$$

$$Adj R^2 = 0.75, \quad F - stat = 450.17$$

Улс төрийн тогтвортой байдлын индекс:

$$y_i = 8349.16 + 7339.49 * ind_i + e_i$$

$$t - stat \quad (14.31) \quad (10.81)$$

$$st.e \quad (583.44) \quad (679.17)$$



$$Adj R^2 = 0.44, \quad F - stat = 116.78$$

Дээрх индекс тус бүрийн хувьд хийсэн үнэлгээний үр дүнд үндэслэн дээрх индексүүд 0.1 функтээр өсөхөд нэг хүнд ноогдох ДНБ ямар хэмжээгээр нэмэгдэхийг сонирхвол:

Сонголт ба Хариуцлагатай байдлын индекс 0.1 функтээр өсөхөд 8.3 хувиар, Авилгалын хяналтын индекс 0.1 функтээр өсөхөд 850.7 ам.\$-оор, Засгийн газрын үр ашигтай байдлын индекс 0.1 функтээр өсөхөд 878.5 ам.\$-оор, Хууль дээдлэлтийн индекс 0.1 функтээр өсөхөд 858.6 ам.\$-оор, Улс төрийн тогтвортой байдлын индекс 0.1 функтээр өсөхөд 733.9 ам.\$-оор тус тус өсөх үр дүн харагдаж байна.

III

Дээрх таван дэд түүвэр тус бүрийн хувьд засаглалын чанар улс орнуудын эдийн засгийн өсөлтийн түвшинд ялгаатай байдлын шалтгаан болж байгаа эсэхийг одоо авч үзье.



Буурай хөгжилтэй улс орнуудын хувьд засаглалын чанар нь эдийн засгийн өсөлтийн дундаж түвшний ялгаатай байдлын шалтгаан болж байна уу? гэдгийг засаглалын 6 индекс тус бүрийн хувьд судалж үзэхэд Сонголт ба Хариуцлагын индексээс бусад индексүүд нь статистикийн хувьд ач холбогдолтой гарсан. Энэ нь Сонголт ба Хариуцлагын индексээс бусад индексүүдээр засаглалын чанарын асуудлуудын ялгаатай байдал нь улс орнуудын хувьд эдийн засгийн өсөлтийн дундаж түвшний ялгаатай байдлын шалтгаан болдог, боловч Сонголт ба Хариуцлагатай байдлын индекс нь дээрх ялгаатай байдлын шалтгаан болохгүй гэдгийг илэрхийлж байна.

Авилгалын хяналтын индекс:

$$y_i = 3.365 + 5.17 * ind_i + 1.77 * DUM + e_i$$

$$t - stat \quad (4.35) \quad (4.6) \quad (1.78)$$

$$st.e \quad (0.77) \quad (1.12) \quad (0.99)$$

$$Adj R^2 = 0.34, \quad F - stat = 10.61$$

Засгийн газрын үр ашигтай байдлын индекс:

$$y_i = 3.53 + 4.56 * ind_i + e_i$$

$$t - stat \quad (5.16) \quad (5.32)$$

$$st.e \quad (0.68) \quad (0.86)$$

$$Adj R^2 = 0.42, \quad F - stat = 28.31$$

Хууль дээдлэлтийн индекс:

$$y_i = 2.44 + 2.89 * ind_i + e_i$$

$t - stat$	(2.8)	(2.7)
$st.e$	(0.87)	(1.07)
$Adj R^2 = 0.15,$	$F - stat = 7.28$	

Зохицуулалтын чанарын индекс:

$$y_i = 2.09 + 3.03 * ind_i + e_i$$

$t - stat$	(3.56)	(3.85)
$st.e$	(0.59)	(0.79)
$Adj R^2 = 0.27,$	$F - stat = 14.83$	


Улс төрийн тогтвортой байдлын индекс:

$$y_i = 1.2 + 1.4 * ind_i + e_i$$


$t - stat$	(2.38)	(2.82)
$st.e$	(0.51)	(0.5)
$Adj R^2 = 0.16,$	$F - stat = 7.94$	

Хөгжиж буй улс орнуудын хувьд засаглалын чанар нь эдийн засгийн өсөлтийн дундаж түвшний ялгаатай байдлын шалтгаан болж байна уу? гэдгийг засаглалын 6 индекс тус бүрийн хувьд судалж үзэхэд индексүүд бүгд статистикийн хувьд найдваргүй гарсан. Иймээс засаглалын чанар хөгжиж буй улсуудын хувьд эдийн засгийн өсөлтийн дундаж түвшний ялгаатай байдлын шалтгаан болно гэж хэлж чадахгүй. Гэхдээ дээрх 6 индекс болон эдийн засгийн өсөлтийн дундаж түвшний хоорондох хамаарлыг графикаар авч үзэхэд дараах зүй тогтол ажиглагдаж байна.


GDP1RATE vs. REG




GDP1RATE vs. LAW




GDP1RATE vs. EFFECT




GDP1RATE vs. STAB



GDP1RATE vs. ACCOUNT



GDP1RATE vs. CORRUP



Дээрх зургаас Сонголт ба Хариуцлагын индекс, Авилгалын индекс, Хууль дээдлэлтийн индекс, Зохицуулалтын чанарын индексүүд эдийн засгийн өсөлтийн дундаж түвшинд эерэг, харин Засгийн газрын үр ашгийн индекс, Улс төрийн тогтворгүй байдлын индекс нь сөрөг нөлөөтэй байж магадгүй гэсэн зүй тогтол ажиглагдаж байна.

Өндөр орлоготой улс орнуудын хувьд засаглалын чанар нь эдийн засгийн өсөлтийн дундаж түвшний ялгаатай байдлын шалтгаан болж байна уу? гэдгийг засаглалын 6 индекс тус бүрийн хувьд судалж үзэхэд Зохицуулалтын чанарын индексээс бусад индексүүд нь статистикийн хувьд ач холбогдолгүй гарсан. Энэ нь Зохицуулалтын чанарын индексээс бусад индексүүд нь өндөр орлоготой улс орнуудын хувьд эдийн засгийн өсөлтийн дундаж түвшний ялгаатай байдлын шалтгаан болохгүй, харин Зохицуулалтын чанарын индекс нь дээрхийн ялгаатай байдлын шалтгаан болно гэдгийг илэрхийлж байна.

Зохицуулалтын чанарын индекс:

$$y_i = 1.73 * ind_i + e_i$$

$$t - stat \quad (9.68)$$

$$st.e \quad (0.18)$$

$$Adj R^2 = 0.16$$

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн улс орнуудын хувьд засаглалын чанар нь эдийн засгийн өсөлтийн дундаж түвшний ялгаатай байдлын шалтгаан болж байна уу? гэдгийг засаглалын 6 индекс тус бүрийн хувьд судалж үзэхэд Зохицуулалтын чанарын индексээс бусад индексүүд нь статистикийн хувьд ач холбогдолгүй гарсан. Энэ нь Зохицуулалтын чанарын индексээс бусад индексүүд нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн улс орнуудын хувьд эдийн засгийн өсөлтийн дундаж түвшний ялгаатай байдлын шалтгаан болохгүй, харин Зохицуулалтын чанарын индекс нь дээрхийн ялгаатай байдлын шалтгаан болно гэдгийг илэрхийлж байна.

Зохицуулалтын чанарын индекс:

$$y_i = 1.17 + 0.63 * ind_i + 3.19 * DUM + e_i$$

$$t - stat \quad (2.92) \quad (1.93) \quad (8.04)$$

$$st.e \quad (0.4) \quad (0.33) \quad (0.4)$$

$$Adj R^2 = 0.71, \quad F - stat = 35.31$$

Түүвэрт багтсан нийт улс орнуудын хувьд засаглалын чанар нь эдийн засгийн өсөлтийн дундаж түвшний ялгаатай байдлын шалтгаан болж байна уу? гэдгийг засаглалын 6 индекс тус бүрийн хувьд судалж үзэхэд бүх индексүүд бүгд статистикийн хувьд ач холбогдолтой гарсан. Энэ нь засаглалын чанарыг илэрхийлсэн дээрх 6 үзүүлэлтээр илэрхийлэгдсэн засаглалын чанарын асуудлын ялгаатай байдал нь ихэнх улс орнуудын хувьд эдийн засгийн өсөлтийн дундаж түвшин буюу нэг хүнд ноогдох ДНБ-ий өсөлтийн хувийн дундаж түвшний ялгаатай байдлыг шалтгаан болж байна гэдгийг харуулж байна.

Сонголт ба Хариуцлагатай байдлын индекс:

$$y_i = 1.38 + 0.59 * ind_i + e_i$$

$$t - stat \quad (9.13) \quad (3.51)$$

$$st.e \quad (0.15) \quad (0.17)$$

$$Adj R^2 = 0.07, \quad F - stat = 12.31$$

Авилгалын хяналтын индекс:

$$y_i = 1.34 + 0.76 * ind_i + e_i$$

$$t - stat \quad (9.26) \quad (5.08)$$

$$st.e \quad (0.14) \quad (0.15)$$

$$Adj R^2 = 0.14, \quad F - stat = 25.84$$

Засгийн газрын үр ашигтай байдлын индекс:

$$y_i = 1.32 + 0.92 * ind_i + e_i$$

$$t - stat \quad (9.37) \quad (6.03)$$

$$st.e \quad (0.14) \quad (0.15)$$

$$Adj R^2 = 0.19, \quad F - stat = 36.31$$

Хууль дээдлэлтийн индекс:

$$y_i = 1.34 + 0.75 * ind_i + e_i$$

$$t - stat \quad (9.19) \quad (4.88)$$

$$st.e \quad (0.15) \quad (0.15)$$

$$Adj R^2 = 0.13, \quad F - stat = 23.84$$

Зохицуулалтын чанарын индекс:

$$y_i = 1.26 + 0.94 * ind_i + e_i$$

$t - stat$	(8.55)	(5.11)
$st.e$	(0.15)	(0.18)
$Adj R^2 = 0.14,$	$F - stat = 26.09$	

Улс төрийн тогтвортой байдлын индекс:

$$y_i = 1.34 + 0.74 * ind_i + e_i$$

$t - stat$	(9.01)	(4.29)
$st.e$	(0.15)	(0.17)
$Adj R^2 = 0.11,$	$F - stat = 18.43$	

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- ➔ Засаглалын чанар улс орнуудын орлогын ялгаатай байдлыг тайлбарлагч нэг чухал зүйл бөгөөд засаглалын чанар илүү сайн улс орнууд нь илүү өндөр орлоготой байна.
- ➔ Улс орнуудыг бүлэглэн авч үзэхэд нэг хүнд ноогдох орлогыг шалгуур болгож үзвэл буурай хөгжилтэй болон, хөгжиж буй орнуудын хувьд авилгалын хянах нь, өндөр орлоготой орнуудын хувьд улс төрийн тогтвортой байдал, OECD-ийн гишүүн орнуудын хувьд зохицуулалтын чанар илүү ач холбогдолтой байна.
- ➔ Буурай хөгжилтэй орнууд эдийн засгийн өндөр өсөлттэй байхын тулд Авилгалын хяналтын индекс, Засгийн газрын үр ашигтай байдлын индекс, Хууль дээдлэлтийн индекс, Зохицуулалтын чанарын индекс, Улс төрийн тогтвортой байдлын индекс зэргээр хэмжигдэж буй засаглалын чанарын асуудлуудыг сайжруулах шаардагатай.
- ➔ Өндөр орлоготой болон OECD-ийн гишүүн улс орнууд эдийн засгийн өндөр өсөлттэй байхын тулд зохицуулалтын чанарыг сайжруулах хэрэгтэй.

- ➔ Засаглалын чанарын асуудал нь улс орнуудын эдийн засгийн өсөлтийн өсөлтийн түвшний ялгаатай байдлыг тайлбарлах чухал хүчин зүйл бөгөөд чанартай сайн засаглалтай улс орнууд илүү өндөр эдийн засгийн өсөлттэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

- Francisco L. Rivera-batiz, Columbia University, "Institution, Governance and Economic Growth", 2004
- Daniel Kaufmann, Aart Kraay, Pablo Zoido-Lobaton "Governance Matters" World Bank
- The World Bank "World development Indicators", 2002
- The World Bank "World development Report", 2004
- www.worldbank.org
- Damodar N. Gujarati "Basic Econometrics", 3rd edition